

Нийслэлийн засаг даргын 1998 оны тоот
 А-110 захирамжаар батлав.

НИЙСЛЭЛИЙН МАЛ ЭМНЭЛЭГ, ХЯНАЛТЫН АЛБАНЫ ДҮРӨМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1. Нийслэлийн Мал эмнэлэг, хяналтын алба /цаашид Мал эмнэлэг, хяналтын алба гэх / нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал амьтнаас гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэвэр, хүнсний аюулгүй байдлыг хангах талаар гарсан хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, биелэлтийг хангуулах үүрэг бүхий хяналтын байгууллага мөн.

2. Мал эмнэлэг, хяналтын алба нь Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай, Захиргааны хариуцлагын тухай хуулиуд болон мал эмнэлгийн улсын хяналтын дүрэм, тэдгээртэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, бусад холбогдох хууль, тогтоомж, энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

3. Нийслэлийн хэмжээнд мал эмнэлгийн улсын хяналтыг эрх бүхий мал эмнэлгийн улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

Хоёр. Нийслэлийн мал эмнэлэг, хяналтын албаны удирдлага, зохион байгуулалтын бүтэц

1. Мал эмнэлэг, хяналтын алба нь Нийслэлийн захирагчийн ажлын албаны дэргэдэх тохируулагч агентлагийн статустайгаар ажиллах бөгөөд ХААҮ Яамны Хөдөө аж ахуйн улсын хяналтын алба, Хөдөө аж ахуйн газраас мэргэжил арга зүйн удирдлагаар хангагдана.

2. Мал эмнэлэг, хяналтын алба нь бие даасан хуулийн этгээд мөн бөгөөд тайлан бланс, харилцах данс, тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх ба төсвөөс бүрэн санхүүжнэ.

3. Мал эмнэлэг, хяналтын албаны дарга буюу улсын ахлах байцаагч, уг албаны улсын байцаагч нарыг Мал эмнэлгийн хяналтын улсын ерөнхий байцаагчтай зөвшилцөн Нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд улсын ахлах болон улсын байцаагчдад улсын байцаагчийн эрхийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн асуудал эрхэлсэн сайд олгоно.

4. Мал эмнэлэг, хяналтын албаны бүтэц, орон тоог тус албаны зорилго, үйл ажиллагааны хүрээ, ажлын ачаалалыг тооцож үзсэний үндсэн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч тогтооно.

5. Мал эмнэлэг, хяналтын албаны дарга нь улсын байцаагч эмч нартай үр дүнгийн гэрээ байгуулан ажиллана.

6. Алба нь өөрийн чиглэлийн дагуу Хөдөө аж ахуйн улсын хяналтын алба, Хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн захирагчийн ажлын албанд хагас, бүтэн жилээр ажлаа тайлагнана.

Гурав. Мал эмнэлэг, хяналтын албаны үүрэг.

Мал эмнэлэг хяналтын алба нь үйл ажиллагааныхаа хүрээнд дараах чиглэлээр үүрэг хүлээж ажиллана.

1. Мал, амьтны өвчлөл, хорогдол, өвчний гаралт тархалт эмчилгээ, оношлогооны байдалд хяналт тавьж, дүгнэлт гаргаж санал боловсруулан шийдвэрлүүлэх.

2. Мал амьтны халдварт паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, түүнд зориулан улсын төсвөөс санхүүжүүлэн олгосон эм бэлдмэлийн зарцуулалт, хадгалалт, хэрэглээнд хяналт тавих.

3. Мал амьтны халдварт, гоц халдварт өвчин илэрсэн тохиолдолд дээд шатны байгууллагад мэдэгдэх, өвчний оношийг тогтоох, тархалтыг зогсоох, түүнийг устгах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх.

4. Нийслэлийн хэмжээнд малын эм бэлдмэлийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэн явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих.

5. Мал, амьтнаас гаралтай түүхий эдээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын бүтээгдэхүүн бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах, хүлээн авах газрын үйл ажиллагаа нь мал эмнэлэг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад тохирч байгаа эсэхэд графикийн дагуу хяналт шалгалт хийх.

6. Нийслэлийн нутаг дэвсгэрт нэвтрэн орж буй мал, амьтан, түүхий эд, бүтээгдэхүүний халдварт, гоц халдварт өвчнөөр тайван нутгаас бэлтгэгдсэн, тэдгээр нь чанар байдлаа алдаагүй болохыг тодорхойлон олгосон орон нутгийн мал эмнэлгийн байгууллагын ариун цэврийн гэрчилгээг шалгаж, зөрчилтэй бол анхдагч үзлэг хийж лабораторийн шинжилгээнд дээж авч дүгнэлт гаргуулан шийдвэрлэнэ.

7. Мал амьтны халдварт өвчин гарсан үед авч хэрэгжүүлж буй хорио цээр, хязгаарлалтын арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомж, зааврын дагуу хянаж гүйцэтгэлийг хангуулах.

8. Мал эмнэлгийн хяналтын үйл ажиллагааг бусад хяналтын албадтай уялдуулан зохион байгуулах.

9. Мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуй, хорио цээрийн талаар хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлийг ашиглан сурталчилгаа явуулах.

10. Мал эмнэлгийн болон хяналтын ажлын тайлан мэдээ, судалгааг графикт хугацаанд нь гарган нэгтгэн дүгнэж, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба, Хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн захирагчийн ажлын албанд ирүүлэх.

11. Мал эмнэлэг, хяналтын албаны лаборатори нь нийслэлийн нутаг дэвсгэрээс экспортонд гарч байгаа мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг шинжилгээ хийж сертификат олгох.

12. Дүүргийн мал эмнэлэг, үржлийн алба, аж ахуйн нэгжүүдийн дэргэдэх лабораториудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.

13. Хүнсний бүтээгдэхүүнд хийж буй үзлэг шинжилгээний үнэн зөвд хяналт тавьж, шаардлагатай бол дээж авч баталгаажуулалт хийх.

14. Нийслэлийн нутаг дэвсгэрт гарч байгаа мал амьтны элдэв өвчнүүдийн гаралт, тархалт, хөдлөл зүйг бүртгэн боловсруулсан иж бүрэн судалгаатай байх.

15. Лабораторийн оношлогоо, магадлан шинжилгээнд дээж авах болон шинжилгээг зохих батлагдсан арга зүй, стандартын дагуу үнэн зөв хийхийн зэрэгцээ шинжилгээний бүртгэлийг нарийн хөтөлж, дээжийг устгах бүрт акт үйлдэх.

16. Өвчний онош батлуулах, тодруулах, маргаан шийдвэрлүүлэх зорилгоор зохих журмын дагуу дээж авч шинжлэн хянан баталгаажуулалт гаргах, шаардлагатай гэж үзвэл бусад баталгаат лаборатори, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагаар дүгнэлт гаргуулж болно.

17. Мал, амьтнаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

18. Мал эмнэлгийн эм биобэлдмэл, багаж төхөөрөмжийн төлөвлөлт захиалга хийх эдгээрийг татан авах, хадгалах хувиарлах зарцуулах, эм, биобэлдмэлийн нөөцтэй байх ажлыг зохион байгуулах.

19. Нутаг дэвсгэрийн нэг нэгж дээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн өөр хэвшлийн мал эмнэлгийн байгууллага, тэдгээрийн мэргэжилтэнүүдийн ажлыг шалгах, дүгнэх.

**Дөрөв. Нийслэлийн мал эмнэлэг, хяналтын
албаны эрх.**

Мал эмнэлэг хяналтын алба нь дор дурьдсан эрхийг эдлэнэ.

1. Байгууллагын эд хөрөнгө, төсвийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулах ба барилга байгууламж, машин, техник, тоног төхөөрөмжийг засварлан

54
сэлбэх, шинээр олох, барьж байгуулах, эдэлгээ ашиглалтыг нь сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх

2. Мал эмнэлэг, хяналтын албаны дарга өөрийн эрх хэмжээнийхээ дагуу тушаал гаргах, гэрээ хэлцэл байгуулах, байгууллагын дотоод журмын дагуу шийдвэр гаргах

3. Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ эрхлэх, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад дүгнэлт гаргах

4. Хяналтын албаны улсын байцаагчид нь батлагдсан үнэмлэх, тэмдэг, албан шаардлага, акт, торгууль, шийтгэвэрийн хуудас хэрэглэх

5. Нийслэлийн хэмжээнд мал амьтан, түүхий эд, бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэн явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, буруутай үйл ажиллагаанд нь зохих хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан шийдвэрт заасны дагуу хариуцлага хүлээлгэх.

6. Холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд үнэмлэлт дүгнэлт өгөх, санал хүсэлтийг дээд шатны байгууллагуудад уламжлах, санал боловсруулж шийдвэрлүүлэх

7. Мал, амьтныг нийслэлийн нутаг дэвсгэрт оруулах, гаргах, нутаг дэвсгэрийн нэг нэгжээс нөгөөд шилжүүлэх, түүхий эд бүтээгдэхүүнийг бэлтгэх, хадгалах худалдах, боловсруулах газрын үйл ажиллагаанд хяналт тавих, зохих журмын дагуу дүгнэлт гаргах

8. Мал эмнэлэг ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангаагүй мал, амьтны халпаа, байр, тоног хэрэгсэл, хэвтэр бууд, уст цэг, билчээр зэргийг зохих нөхцлийг хангаж сайжруулах хүртэл ашиглахыг хориглох

9. Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэн явуулдаг аж ахуйн нэгж байгууллага иргэдийн үйл ажиллагаа нь хүний эрүүл мэндэд хор хохирол учруулах, мал амьтны өвчин тараах нь тогтоогдсон болон мал

эмнэлэг ариун цэвэр,эрүүл ахуйн хэм хэмжээг зөрчсөн бол зохих хууль тогтоомжийн дагуу дараах арга хэмжээ авна Үүнд:

- ◆ Албан шаардлага өгөх,торгох,буруутай үйл ажиллагааг таслан зогсоох
- ◆ Үйл ажиллагааг нь түр буюу бүрмөсөн зогсоох,бүтээгдэхүүн үйлдвэрлэх,худалдан борлуулахыг хориглох бүтээгдэхүүнийг өөрсдийн хяналтын дор устгуулах,ажил үйлчилгээний байр талбайд шаардлагаар ариутгал,халдваргүйжүүлэлт хийлгэх,энэ тухай хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр олон нийтэд мэдээлэх

10.Илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт,холбогдох баримт бичгийг бүрдүүлэн эрх бүхий байгууллагад шилжүүлэх

11.Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар асуудал боловсруулж Нийслэлийн засаг даргын зөвлөл,Иргэдийн төлөөлөгчдийн хуралд оруулж шийдвэрлүүлэх

12.Төрөл бүрийн мал,амьтан,түүнээс гаралтай түүхий эд,хүнсний бүтээгдэхүүн,тэжээлээс дээж авч,оношлогоо шинжилгээ хийх дүгнэлт гаргах

13.Хууль тогтоомжоор олгогдсон бусад бүрэн эрхийг эдлэнэ.

Тав.Мал эмнэлэг,хяналтын албаны хяналт тавих газрууд.

Хяналтын албаны үйл ажиллагааны хүрээнд нийслэлийн хэмжээнд мал,амьтан,түүхий эд,бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэн явуулж байгаа улсын болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж,байгууллага,дүүргийн мал эмнэлэг үржлийн алба тэдгээрийн удирдлага,албан тугаалтан,иргэд /цаашид аж ахуйн нэгж байгууллага,иргэд гэх/ хамаарна. Үүнд:

1.Хүн амын хүнсний хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдсан хүнсний зах,худалдааны төвүүд,тэнд нийтийн хэрэгцээнд худалдан борлуулж байгаа мал,амьтны гаралтай бүтээгдэхүүн /өндөг,мах,сүү,цагаан идээ,хиам гэх мэт./

2. Мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн /бүх төрлийн мал, амьтны мах, сүү, өндөг ноос ноолуур, арьс шир, төрөл бүрийн дайвар бүтээгдэхүүн /, малын тэжээл, амьтны гаралтай бордоо зэрэг үйлдвэрлэл явуулдаг үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэн

3. Импортын болон экспортын зориулалтаар ажиллаж байгаа хүнс түүхий эдийн захууд

4. Нийтийн хэрэгцээнд мал, амьтан, түүхий эдээр үйлчилгээ явуулж буй хүнсний дэлгүүр, нийтийн хоолны газар, цэг

5. Мал, амьтны нядалгааны газар.

6. Дүүргийн мал эмнэлэг, үржлийн албад, УҮГ аж ахуйн нэгжийн дэргэдэх лаборатори

7. Төрөл бүрийн мал, гахай, шувууны аж ахуй эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэд

8. Мал, амьтны зориулалттай том, бэлдмэлийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэн явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага

9. Мал, амьтан, түүхий эд, бүтээгдэхүүнийг нийслэлд нэвтрүүлэх товчоо, тэдгээрийг тээвэрлэсэн бүх төрлийн тээврийн хэрэгсэл

10. Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэн явуулж буй бусад холбогдох аж ахуйн нэгж, байгууллага хамаарна.

**Зургаа. Хяналтын албыг өөрчлөн зохион байгуулах,
таган буулгах.**

Мал эмнэлэг хяналтын албыг Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан үндэслэлээр өөрчлөн зохион байгуулах, татан буулгаж болно.

Долоо. Дүрмийн биелэлтэнд хяналт тавих.

1. Дүрсийн биелэлтэнд ХАА-н улсын хяналтын алба, Нийслэлийн захирагчийн ажлын алба, хяналт тавина.

2. Дүрмийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.